

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
Нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ
ДОХ-ЫН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Н.ЦОГЗОЛМАА ТАНАА

2021.02.25 № 07/520
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 18 дугаар зүйлийн 18.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Төслийн хүрээнд ХДХВ, ДОХ, БЗДХ-ын эмчилгээ, тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр 280 гаруй үйл ажиллагаа төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
	МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АУДИЛТГАХ ХӨРӨНГӨ	270,334,248.59	373,476,499.20
	Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	270,334,248.59	373,476,499.20
	АВЛАГА	29,680,679.26	55,991,560.73
	Бусад авлага	29,680,679.26	55,991,560.73
	УРЬДЧИЛГАА	1,424,400.00	-
	Урьдчилж гарсан зардал	1,424,400.00	-
	БАРАА МАТЕРИАЛ	330,174,900.42	-
	Хангамжийн материал	330,174,900.42	-
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	631,614,228.27	429,468,059.65
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
	Биет хөрөнгө	24,633,588.62	21,337,108.15
	Авто тээврийн хэрэгсэл	117,814,396.72	117,814,396.72
	Хуримтлагдсан элэгдэл	(117,814,396.72)	(117,814,396.72)
	Машин тоног төхөөрөмж (компьютер)	61,993,090.95	38,481,146.54
	Хуримтлагдсан элэгдэл	(44,111,919.69)	(26,661,596.49)
	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,994,058.68	21,440,004.22
	Хуримтлагдсан элэгдэл	(23,241,641.32)	(11,922,446.12)
	Биет бус хөрөнгө	4,200,000.00	2,100,000.00
	Програм хангамж	8,400,000.00	8,400,000.00
	Хуримтлагдсан элэгдэл	(4,200,000.00)	(6,300,000.00)
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	28,833,588.62	23,437,108.15
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	660,447,816.89	452,905,168.08
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
	Өглөг	82,962,486.15	-
	Бусад өглөг	82,962,486.15	-
	Урьдчилж орсон орлого	293,529,048.59	373,476,499.20
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	376,491,534.74	373,476,499.20
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	376,491,534.74	373,476,499.20
	ЭЗНИЙ ӨМЧ		
	Хуримтлагдсан үр дүн	283,956,282.15	79,428,668.88
	Өмнөх үеийн үр дүн	283,956,282.15	232,833,880.54
	Тайлант үеийн үр дүн	-	(153,405,211.66)
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	283,956,282.15	79,428,668.88
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	660,447,816.89	452,905,168.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,568,783,774.33	2,441,767,402.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,556,924,183.49	2,363,179,900.73
120	Нийтлэг татварын бус орлого	2,357,946,232.37	1,826,576,840.54
1200043	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,357,946,232.37	1,826,576,840.54
122	Тусламжийн орлого	198,977,951.12	536,603,060.19
122002	Хандив тусламж /гадаад/	198,977,951.12	536,603,060.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,859,590.84	78,587,501.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,859,590.84	78,587,501.28
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	11,859,590.84	78,587,501.28
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,505,700,097.04	2,625,017,838.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,505,700,097.04	2,625,017,838.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,493,840,506.20	2,546,430,337.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	593,559,675.12	585,001,394.70
210101	Үндсэн цалин	593,559,675.12	585,001,394.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,793,601.26	8,755,392.56
210201	Тэтгэврийн даатгал	20,793,601.26	8,755,392.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,619,724.56	201,452,066.56
210301	Гэрэл, цахилгаан	3,171,502.56	454,370.56
210304	Байрны түрээс	218,448,222.00	200,997,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	142,984,344.97	153,300,236.07
210401	Бичиг хэрэг	20,219,843.81	8,535,717.45
210402	Тээвэр, шатахуун	32,713,181.24	43,175,038.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,048,968.10	7,745,541.05
210404	Ном, хэвлэл	49,375,971.82	62,363,523.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,626,380.00	31,480,416.37
2105	Нормативт зардал	253,743,520.27	933,013,824.68
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	253,743,520.27	933,013,824.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,246,630.00	11,859,127.00
210601	Багаж, техник хэрэгсэл	4,739,700.00	11,859,127.00
210602	Тавилга	11,506,930.00	
2107	Томилолт, зочны зардал	158,905,453.00	31,869,000.00
210701	Гадаад албан томилолт	95,209,610.00	
210702	Дотоод албан томилолт	63,695,843.00	31,869,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,491,106.26	63,885,500.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр	119,213,746.26	53,160,500.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	41,136,364.00	10,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,996.00	
210806	Мэдээлэл технологийн зардал		725,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	925,496,450.76	557,293,795.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	322,565,801.38	88,581,128.18
210902	Сургалт семинарын зардал	588,481,620.26	455,236,531.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,449,029.12	13,476,136.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,859,590.84	78,587,501.28
213101	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,859,590.84	78,587,501.28
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	63,083,677.29	(183,250,436.86)
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	12,942,293.83	29,845,225.20
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз	12,942,293.83	23,238,191.53

145004	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз		6,607,033.67
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	32,766,620.20	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	32,766,620.20	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV-V)	(19,824,326.37)	29,845,225.20
	НИЙТ ҮР ДҮН	43,259,350.92	(153,405,211.66)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,969,346,030.87	1,907,006,468.51
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,969,346,030.87	1,907,006,468.51
120	Нийтлэг татварын бус орлого	1,969,346,030.87	1,907,006,468.51
120002	Хүүгийн орлого	6,920,836.32	2,333,876.29
1200043	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,962,425,194.55	1,904,672,592.22
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,376,802,161.83	1,823,871,808.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,376,802,161.83	1,823,871,808.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,376,802,161.83	1,823,871,808.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	596,488,839.64	584,692,284.42
210101	Үндсэн цалин	596,488,839.64	584,692,284.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,288,836.74	8,755,392.56
210201	Тэтгэврийн даатгал	19,288,836.74	8,755,392.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,329,808.56	201,338,666.56
21301	Гэрэл, цахилгаан	3,956,586.56	454,370.56
210304	Байрны түрээс	218,373,222.00	200,884,296.00
2104	Хангамж, бараа материалын зардал	142,482,323.97	129,400,428.80
210401	Бичиг хэрэг	19,676,543.81	7,749,176.36
210402	Тээвэр, шатахуун	32,634,581.24	43,313,438.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,508,167.10	8,803,131.05
210404	Ном, хэвлэл	49,686,971.82	38,175,663.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,976,060.00	31,359,020.19
2105	Нормативт зардал	190,351,721.82	217,029,071.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	190,351,721.82	217,029,071.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,859,127.00	-
210601	Багаж, техник хэрэгсэл	11,859,127.00	
2107	Томилолт, зочны зардал	155,174,690.00	32,139,950.00
210702	Дотоод албан томилолт	95,209,610.00	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	59,965,080.00	32,139,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165,035,567.34	88,474,167.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр	123,303,077.88	77,991,990.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	41,136,364.00	10,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,996.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	455,129.46	482,177.35
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	873,791,246.76	562,041,847.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	314,325,626.50	88,495,649.18
210902	Сургалт семинарын зардал	559,465,620.26	473,546,198.27
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(407,456,130.96)	83,134,659.92
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,794,000.00	8,079,655.79
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,794,000.00	8,079,655.79
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(4,794,000.00)	(8,079,655.79)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	24,036,480.02	28,087,246.48
24	Санхүүгийн үйл ажиллагааны орлогын дүн	24,036,480.02	28,087,246.48
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз	24,036,480.02	28,087,246.48
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(388,213,650.94)	103,142,250.61
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	658,547,899.53	270,334,248.59
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	270,334,248.59	373,476,499.20

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	838,531,048.76	838,531,048.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	(597,834,117.53)	(597,834,117.53)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	-	-
4	Тайлант үеийн үр дүн	0.00	43,259,350.92	43,259,350.92
5	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	283,956,282.15	283,956,282.15
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	(51,122,401.61)	(51,122,401.89)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	232,833,880.54	232,833,880.54
8	Тайлант үеийн үр дүн	0.00	(153,405,211.66)	(153,405,211.66)
9	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	79,428,668.88	79,428,668.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төсөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		270,334,248.59		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,951,489,336.44	2,368,554,514.57	417,065,178.13	121.4
УРСГАЛ ЗАРДАЛ	1,951,489,336.44	2,368,554,514.57	417,065,178.13	121.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,951,489,336.44	2,368,554,514.57	417,065,178.13	121.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	600,164,510.40	584,692,284.42	(15,472,225.98)	97.4
Үндсэн цалин	600,164,510.40	584,692,284.42	(15,472,225.98)	97.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,655,215.00	8,755,392.56	(4,899,822.44)	64.1
Тэтгэврийн даатгал	13,655,215.00	8,755,392.56	(4,899,822.44)	64.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	201,450,000.00	201,338,666.56	(111,333.44)	99.9
Гэрэл, цахилгаан	450,000.00	454,370.56	4,370.56	101.0
Байрны түрээс	201,000,000.00	200,884,296.00	(115,704.00)	99.9
Хангамж, бараа материалын зардал	133,846,904.00	129,400,418.80	(4,446,485.20)	96.7
Бичиг хэрэг	8,000,000.00	7,749,176.36	(250,823.64)	96.9
Тээвэр, шатахуун	44,000,000.00	43,313,428.20	(686,571.80)	98.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,000,000.00	8,803,131.05	(196,868.95)	97.8
Ном, хэвлэл	40,846,904.00	38,175,663.00	(2,671,241.00)	93.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,000,000.00	31,359,020.19	(640,979.81)	98.0
Нормативт зардал	324,808,881.04	729,632,131.64	404,823,250.60	224.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	315,309,601.04	729,632,131.64	414,322,530.60	231.4
Хоол, хүнс	9,499,280.00		(9,499,280.00)	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	677,563,826.00	706,655,964.80	29,092,138.80	104.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	677,563,826.00	706,655,964.80	29,092,138.80	104.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,079,655.79	8,079,655.79	
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	8,079,655.79	8,079,655.79	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,471,696,775.18		
Глобаль сангийн санхүүжилт		1,904,672,592.22		
Шууд төлбөр / Глобаль сангийн санхүүжилт/		536,603,060.19		
Хүүгийн орлого		2,333,876.29		
Тохируулсан орлого		28,087,246.48		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		270,334,248.59		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		373,476,499.20		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6		
Гүйцэтгэх ажилтан	6	6		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн зохицуулагч Н.Цогзолмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төслөөс олгож байгаа хөрөнгө, мөнгөний зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, олгосон санхүүжилтийг үр дүнтэй зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн зохицуулагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Лидер экаунт аудит” ХХК-ийн ахлах аудитор Ш.Уянга хянан удирдаж, аудитор Д.Хонгорзул, аудиторын туслах О.Мөнхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 21/17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннаны санаачилгаар ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх Глобаль санг 2002 онд байгуулсан бөгөөд төлөөлөгчийн газар нь Женев хотод байрладаг. Глобаль сан нь эдийн засгийн хувьд бага, дунд орлоготой орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ тухайн улсын Засгийн газраас зарцуулж буй төсөв, хөрөнгө дээр нэмэлт санхүүжилт олгох, үр дүнд тулгуурласан санхүүжилт хийх зарчмыг баримталдаг.

Монгол Улс 2003-2020 онд ДОХ, Сүрьеэ, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр нийт 62.9 сая ам.долларын буцалтгүй тусламж авсны 24.5 сая ам.долларыг ДОХ-ын хөтөлбөрт зарцуулсан байна.

Монгол Улс, Глобаль сангийн хооронд 2015 оны 03 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан Хамтын ажиллагааны зарчмын тухай гэрээний дагуу Эрүүл мэндийн яам нь Глобаль сангийн санхүүжилтээр ХДХВ/ДОХ өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөгсдөд анхаарал халамж, дэмжлэг туслалцаа үзүүлэх, эмчлэхэд чиглэсэн үндэсний хөтөлбөрүүдээр дамжуулан Монгол Улс дахь ХДХВ-ын бага түвшинд барих MNG-H-MON хөтөлбөрийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлж дуусаад байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр голлон өртөх хүн амын бүлгүүдэд (ГӨХАБ) ээлтэй БЗХӨ, ХДХВ, ДОХ-ын эмчилгээ, халамж үйлчилгээний түвшинг шат ахиулах замаар ГӨХАБ дэх ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулж, нийт хүн амын дунд халдварт өвчин тархахаас сэргийлнэ гэсэн зорилт хэрэгжсэн гэж үзжээ.

Монгол Улсыг 2021-2023 онд Глобаль сангаас төсөл хэрэгжүүлэх боломжтойг мэдэгдсэний дагуу Эрүүл мэндийн яамны боловсруулсан төслийн баримт бичгийг Глобаль сангийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Төслийн гэрээ”-г баталсан байна.

Төсөл нь Монгол Улс дхь ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, эмчилгээ, тусламж үйлчилгээ үзүүлэх Үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх“ чиглэлээр 2021-2023 онд 2.7 сая ам.долларын санхүүжилтийн MNG-H-MON хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болжээ.

Үйл ажиллагааны чиглэл:

ХДХВ-ын бага түвшинд барих MNG-H-MON хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд, трансжендер хүмүүс, эмэгтэй биеэ үнэлэгчид, хар тамхи судсаар тарьж хэрэглэгчид, ялтангууд, эмзэг бүлгийн хүүхэд залууст зориулсан урьдчилан сэргийлэх,
- Эмчилгээ, халамж үйлчилгээний дэмжлэг,
- Бодлого засаглал,
- Эрүүл мэндийн мэдээллийн менежментийн систем.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,538,466.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 50,769.3 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 207,542.6 мянган төгрөгөөр буюу 31.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	270,334.2	373,476.5	103,142.3
Авлага	29,680.7	55,991.6	26,310.9
Урьдчилж төлсөн зардал	1,424.4	-	(1,424.4)
Бараа материал	330,174.9	-	(330,174.9)
Үндсэн хөрөнгө	28,833.6	23,437.1	(5,396.5)
Нийт хөрөнгө	660,447.8	452,905.2	(207,542.6)
Богино хугацаат өр төлбөр	376,491.5	373,476.5	(3,015.0)
Хуримтлагдсан үр дүн	283,956.3	79,428.7	(204,527.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	660,447.8	452,905.2	(207,542.6)

Авлага дансны үлдэгдэл 55,991.6 мянган төгрөг болж, 26,310.9 мянган төгрөгөөр өссөн нь гадаад ханган нийлүүлэгч байгууллагуудад захиалсан эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлтээс шалтгаалжээ. Авлага нь 55,991.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 23,437.1 мянган төгрөг болж, 5,396.5 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн А-1/1961 тоот шийдвэрийн дагуу ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 33 төрлийн 40,145.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улс, Глобаль сангийн Хамтын ажиллагааны зарчмын тухай гэрээний дагуу 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх төслийн санхүүжилтанд баримтлах төгрөгийн ханшийг 2,374.82 төгрөгөөр тогтоож, төслийн бүртгэлд мөрдөж байна.

Глобаль сан тайланд онд 1,951,489.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс 1,904,672.6 мянган төгрөг санхүүжилтээр, 536,603.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжөөр, нийт 2,441,275.6 мянган төгрөгийг олгожээ.

Глобаль сангаас тайлант онд олгосон санхүүжилтээс 97.0 хувь буюу 2,368,554.5 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилт

Төслөөс олгосон санхүүжилт нь 489,786.3 мянган төгрөгөөр илүү байгаа нь 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжих Ковид-19 цар тахалтай тэмцэх арга хэмжээнд зориулан олгосон нэмэлт санхүүжилт байна.

Эрүүл мэндийн яамны зохион байгуулсан Коронавирус халдварын үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эмнэлгийн зориулалттай нарийн шүүлтүүртэй N95 амны хаалт нийлүүлэх тендерт шалгарч, тус яамтай гэрээ байгуулсан “Дөрвөн Жи Трейдинг” ХХК-д 171,923.4 мянган төгрөгийг Глобаль сангийн ДОХ-ын төслөөс санхүүжүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 130 мэдээллийг хугацаанд байршуулж, 19 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Төслөөс өөрийн үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтыг шилэн дансны мэдээлэлд бүрэн оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Эрүүл мэндийн сайдын тушаал гараагүйн улмаас хуваарилагдаагүй үлдэгдэл 216,063.2 мянган төгрөгийн эм, эмнэлэгийн бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилж зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	216,063.2	2	216,063.2	-	-	-
Нийт дүн	2	216,063.2	2	216,063.2	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 40,905.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 40,905.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгч менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Глобаль сангийн санхүүжилтээр салбар хүлээн авагч байгууллагуудад олгосон санхүүжилтийн гүйцэтгэл, төслөөс эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан эмнэлгийн тоног төхөөрөмжийг тухайн хүлээн авагчийн данс бүртгэлд бүрэн тусгаж авсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

"Баянгол мед" ХХК-аас 24,000.0 мянган төгрөгөөр автоклав, "Лайфтроник" ХХК-аас 12,405.0 мянган төгрөгөөр лабораторийн дагалдах хэрэгсэл тус тус худалдан авсан ч хүлээн авсан тухай акт үйлдээгүй байна.

1.2. Эрсдэл:

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"-ыг зөрчих

1.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан журмын 9.1.11-д "төслийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэхээр сонгон шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах, биелэлтэд нь хяналт тавих хэрэгжилтийг хангуулах, дүгнэх" гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2.1. Илрүүлэлт:

Ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг гүйцэтгэгч байгууллага бүрээр шалгахад "АДӨЗ" ХХК-аар 4,500.0 мянган төгрөгийн ДОХ-ын төслийн танилцуулганы эх бэлтгэх, хэвлүүлэх ажил гүйцэтгүүлсэн ч гэрээ дүгнээгүй байна.

2.2. Эрсдэл:

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"-ыг зөрчих

2.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан журмын 9.1.11-д "төслийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэхээр сонгон шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах, биелэлтэд нь хяналт тавих хэрэгжилтийг хангуулах, дүгнэх" гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээллэнэ” гэж заасан санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байх.

3.3. Албан шаардлага:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг заасан хугацаанд байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/80/СТА-ТНХ
Шалгагдсан байгууллагын нэр:	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төсөл		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	"Баянгол мед" ХХК-аас 24,000.0 мянган төгрөгөөр автоклав, "Лайфтроник" ХХК-аас 12,405.0 мянган төгрөгөөр лабораторийн дагалдах хэрэгсэл тус тус худалдан авсан ч хүлээн авсан тухай акт үйлдээгүй байна.	36,405.0	Зөвлөмж	Төслийн зохицуулагч, Санхүүгийн мэргэжилтэн	Н.Цогзолмаа Б.Бадамчимэг
2	Ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг гүйцэтгэгч байгууллага бүрээр шалгахад "АДӨЗ" ХХК-аар ДОХ-ын төслийн танилцуулганы эх бэлтгэх, хэвлүүлэх ажил гүйцэтгүүлсэн ч гэрээ дүгнээгүй байна.	4,500.0	Зөвлөмж	Төслийн зохицуулагч, Санхүүгийн мэргэжилтэн	Н.Цогзолмаа Б.Бадамчимэг
3	Шилэн дансанд нийт 149 мэдээлэл оруулснаас 19 мэдээллийг цаг хугацаа хоцроосон байна.	0.0	Албан шаардлага	Төслийн зохицуулагч, Санхүүгийн мэргэжилтэн	Н.Цогзолмаа Б.Бадамчимэг
ДҮН		40,905.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 73/АО170079
САН-2021/81/СТА-ТХН
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн зохицуулагч Н.Цогзолмаа, санхүүгийн мэргэжилтэн Б.Бадамчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
“ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

П.ШАРАВХОРОЛ